



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
05- ДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 10

Чингис хот


**“Хөгжлийн хөтөч” хөтөлбөр
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тавдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулж, суралцахуйд суралцсан, үндэсний ёс, заншил, соёлыг уламжлагч, хүмүүнлэг нийгмийг бүтээхэд хувь нэмрээ оруулагч, нийгмийн болон гэр бүлийн хариуцлагатай гишүүн, насан туршдаа тасралтгүй суралцан хөгжигч иргэдийг бэлтгэх зорилгоор “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг аймгийн хөгжлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, үр дүнг тооцон жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгэм, хүний хөгжлийн хороо (Ж.Равжих)-нд үүрэг болгосугай.



Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 04 дүгээр сарын 17 өдрийн 05 дугаар
хуралдааны 02 дугаар тогтоолын хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ “ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ” ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Бидний өсвөр үеийг хүн амын өсөлт, эрчимтэй хотжилтын асуудал, уур амьсгалын өөрчлөлт, шинжлэх ухаан технологийн үсрэнгүй хөгжил, хиймэл оюун ухаан их өгөгдлөөс үүдэн ирээдүйн төлөв байдал тодорхойгүй, таамаглахад бэрхтэй, тогтворгүй, ээдрээтэй нийгэм хүлээж байна. Иймээс боловсролыг даяарчлалын хандлагатай үндэсний онцлогтойгоор хөгжүүлэх хэрэгцээ тулгарч байна.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн нэг чухал хэмжээс нь хүний хөгжил бөгөөд улс орны засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол цөм, хөдөлгөгч хүч нь болохын хувьд Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” баталж, хүн төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэ бодлогын 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

Хэнтий аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан тэгш хүртээмжтэй оролцоог дэмжин, орчин сайжруулж, сургалтын чанарыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлээд байна.

Технологийн хурдацтай хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн хувьсал, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, онцлогоос үл хамааран суралцагч нь шинжлэх ухааны мэдлэг, танин мэдэхүй, нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн чадвартай, өөрийн суралцахуйг удирддаг, бусдын санал бодол, үнэт зүйлд хүндэтгэлтэй ханддаг, хөгжих сэтгэлгээтэй хөгжлийн хөтчийг бэлтгэх нэн тэргүүний шаардлага байна.

Элсэлтийн шалгалтын үр дүнг 2017-2024 оноор нэгтгэн үзэхэд монгол хэл, газарзүй, нийгэм, түүхийн судлагдахуун тогтмол улсын дунджаас дээгүүр, байгалийн ухааны судлагдахуунууд хэлбэлзэлтэй, англи хэлний судлагдахуун улсын дундаж оноонд хүрч үнэлэгдээгүй.

2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн хангалт 99.5%, ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт 94.2% байна. Аймгийн хэмжээнд англи хэл, физик, хими, математик, бага боловсрол, хөгжмийн мэргэжлийн багш дутагдалтай байна.

Иймд боловсролын чанар хүртээмжийг сайжруулах, сургалтын үйлийн болон материаллаг орчныг нэмэгдүүлэх, боловсролын салбарын хүний нөөцийг чадавхжуулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулж, суралцахуйд суралцсан, үндэсний ёс, заншил, соёлыг уламжлагч, хүмүүнлэг нийгмийг бүтээхэд хувь нэмрээ оруулагч, эрүүл амьдралын хэв маяг, зөв дадалтай, нийгмийн болон гэр бүлийн хариуцлагатай гишүүн, насан туршдаа тасралтгүй суралцан хөгжигч ирээдүйн иргэдийг бэлтгэхэд оршино.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Зорилт 1: Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн залгамж холбоог бэхжүүлж, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилт 2: Хүүхэд бие даан суралцах, хамтран хөгжих боломж нөхцөл, сургалтын болон үйлийн орчныг бүрдүүлэх

Зорилт 3: Багш нарын мэргэжлийн мэдлэг, багшлах ур чадварыг хөгжүүлэх

Зорилт 4: Хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчид болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах

Зорилт 5: Боловсролын салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

4.1 Хэнтий аймгийн боловсролын байгууллага, суралцагч, багш, удирдлага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч

4.2 Хөтөлбөрийг 2025 – 2028 онд хэрэгжүүлнэ.


ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 1: Цэцэрлэг, ЕБС-ийн сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

- 1.1 Судалгаанд үндэслэн сургуулийн хэв шинжийг өөрчилж, боловсролын байгууллагын менежментийг хэрэгжүүлнэ.
- 1.2 Математик, байгалийн ухаан, мэдээллийн технологи, гоо зүй, гадаад хэлний кабинетын тоо, хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын материаллаг баазыг бэхжүүлнэ.
- 1.3 Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/262 дугаар тушаалын дагуу төрөлжсөн сургалт зохион байгуулах сургуулийн тоог нэмэгдүүлнэ.
- 1.4 ЕБС-ийн суралцагчдад математик, физик, хими, биологи, англи хэл, нийгмийн ухааны хичээлээр онлайн болон танхимын сургалт зохион байгуулна.
- 1.5 ЕБС-ийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний зөрүүг багасгаж, бодитой болгох бодлого баримтална.
- 1.6 Суралцагчдын байгалийн ухаан, нийгмийн ухаан, гоо зүйн мэдлэг чадварыг сайжруулах олон талт ажлыг зохион байгуулж бүтээлч сэтгэлгээ, сэтгэх чадвар, кодчиллол, STEAM, техник технологи, гадаад хэл, унших чадварын өдөрлөгийг зохион байгуулна.
- 1.7 Аймгийн Засаг даргын нэрэмжит массын шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллана.

Зорилт 2: Хүүхэд бие даан суралцах, хамтран хөгжих боломж нөхцөл, сургалтын болон үйлийн орчныг бүрдүүлэх, цахим ур чадварыг нэмэгдүүлэх

- 2.1 Сургууль, цэцэрлэгийн орчинд суралцагч бие даан суралцах, хөгжих, хамтран суралцах, тэгш хамруулан сургах боломж бүхий олон талт өрөө, талбайг тохижуулна.



- 2.2 Суралцагчдын зөөлөн ур чадвар, өөрийгөө танин мэдэх, сэтгэл хөдлөлөө удирдах, бүтээлч санаачилгатай байх, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн харилцах, өв соёлоо дээдлэн уламжлагч, эрүүл амьдралын хэв маяг зөв дадалтай хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдийн санал санаачилгыг дэмжин хамтран ажиллана.
- 2.3 Хүүхэд хөгжил хамгааллын үйл ажиллагаа, суралцагчдын оролцоо манлайллыг дэмжсэн эерэг контентуудыг бүтээж, нийгэмд түгээж ажиллана.
- 2.4 Улсын олимпиад болон элсэлтийн шалгалтад амжилттай оролцсон сурагчдыг урамшуулан дэмжинэ.
- 2.5 Мэдээллийн технологи, AI технологийг хэрэглэгч, түгээгч "Хиймэл оюун ухааны элч хүүхэд"-үүдийг бэлтгэж цахим ур чадвартай суралцагчдын хүрээг өргөжүүлнэ.
- 2.6 Сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, боловсролын байгууллагын хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартад нийцүүлэн сайжруулна.

Зорилт 3: Багш нарын мэргэжлийн мэдлэг, багшлах ур чадварыг хөгжүүлэх

- 3.1 Багш хөгжлийн төвийн орчин, тохижилтыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэн үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 3.2 Багшийн шинэ технологи, арга зүйг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх **"Сайн багш"** үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.3 Багш нарын мэдээлэл харилцааны технологийн ур чадварыг нэмэгдүүлэх, ээлжит хичээлийн бэлтгэл, төлөвлөлтийг тогтмолжуулах, судалгааны арга зүйд суралцах, сургалтын шинэ технологи, арга зүйг туршин нэвтрүүлж, бүсийн хөгжлийг дэмжин ажиллана.
- 3.4 Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулж, багшлахуй, суралцахуйд тулгамдаж буй асуудлаа хамтран шийдвэрлэх, мэргэжлийн онол, арга зүйгээ тасралтгүй хөгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн үр дүнг сайжруулах үйл ажиллагааг цахим, танхим болон хосолсон хэлбэрээр онол, дадлагаар зохион байгуулна.
- 3.5 Удирдах ажилтнуудын манлайлал, менежмент, зөөлөн ур чадвар, эрх зүйн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх цахим болон танхим хосолсон сургалтад оролцуулна.
- 3.6 Улсын олимпиад, ур чадвар, эрдэм шинжилгээний хуралд эхний 3 байранд шалгарсан багшийг болон улсын олимпиад, элсэлтийн шалгалтад шавиа амжилттай бэлтгэсэн багш, бага ангийн багшийг урамшуулан дэмжинэ.
- 3.7 Ахмад залуу багш нарын хамтын ажиллагааг дэмжин, ахмад багш, удирдах ажилтны зөвлөх үйлчилгээг нэвтрүүлж, зөвлөх баг ажиллуулна.

Зорилт 4: Хүүхдийнхээ хөгжлийг дэмждэг эцэг, эх, асран хамгаалагчид, бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

- 4.1 Монгол түүх соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл хандлага болон хүмүүжил төлөвшил, эрүүл амьдрах хэв маягийг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүүхдийн оролцооны байгууллагыг дэмжин ажиллана.
- 4.2 Суралцагчдын хэрэгцээ сонирхолд нийцсэн тэдний авьяас, чадварыг хөгжүүлэх чиглэлийн клуб, секц, дугуйланг ганцаарчилсан, холимог бүлгийн хэлбэрээр зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

- 4.3 Цахим ангийг түшиглэн, боловсролын салбарт ашиглаж буй цахим системүүдийн хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд иргэд, асран хамгаалагчдын мэдээллийн технологийн ур чадварыг сайжруулах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.
- 4.4 Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо дэмжлэг, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж, эерэг контент бүтээж олон нийтэд хүргэнэ.
- 4.5 Гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжил, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн эцэг эхийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

Зорилт 5: Боловсролын гадаад болон дотоод хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэх

- 5.1 Багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамруулах, улс, олон улсын чанартай мэргэжлийн уралдаан, тэмцээнд оролцох, туршлага судлахад дэмжлэг үзүүлнэ.
- 5.2 Боловсролын салбарын үйлчилгээний ажилтан, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.3 Боловсролын байгууллагууд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдтэй хамтран, иргэний боловсрол, хүний хөгжлийн ажлуудыг зохион байгуулна.
- 5.4 Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлсэн багш, боловсролын байгууллагад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.

ЗУРГАА. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- 6.1 Улсын болон аймгийн төсөв
- 6.2 Гадаад улс, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хандив, тусламж
- 6.3 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив
- 6.4 Бусад эх үүсвэр

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

- 7.1 Аймгийн Боловсролын газар нь хөтөлбөрийн анхан шатны боловсруулалт хийж багш, удирдах ажилтны дунд хэлэлцүүлэг өрнүүлж, дэвшүүлсэн саналыг тусган Хяналт – шинжилгээ, үнэлгээний хэлтэст хянуулан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна.
- 7.2 Боловсролын газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах бөгөөд үйл ажиллагааны явцын тайланг гаргаж, зорилт, арга хэмжээний биелэлт, үр дүн, шалгуур үзүүлэлтийг тооцож жил тутамд Хяналт – шинжилгээ, үнэлгээний хэлтэст хянуулан, аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнана.
- 7.3 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангана.
- 7.4 Хөтөлбөрийн явц, үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

- 8.1 Мэргэжлийн мэдлэг, заах арга, ур чадвар дээшлүүлэх сургалтад хамрагдсан багш, арга зүй, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлсэн багшийн тоо, кабинетын тоо нэмэгдсэн байна.
- 8.2 ЕБС-ийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний зөрүү багасаж, төгсөгчдийн сурлагын чанар сайжирч элсэлтийн шалгалтын байр өмнөх оноос ахиж боловсролын чанар хүртээмж сайжирсан байна.
- 8.3 Хүүхэд бие даан суралцах, хамтран хөгжих боломж, орчныг бүрдүүлж оролцоо манлайлал, хөгжил хамгааллыг дэмжсэн ажлуудад оролцсон сурагчдын тоо нэмэгдсэн байна.
- 8.4 Сургууль, цэцэрлэгийн орчинд суралцагч бие даан суралцах, хөгжих, хамтран суралцах боломж бүхий олон талт өрөө, талбай байгуулагдсан байна.
- 8.5 Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлсэн, туршлага судалсан багшийн тоо өссөн байна.
- 8.6 Улсын олимпиад, ур чадвар, эрдэм шинжилгээний хуралд байр эзэлсэн сурагч, багш нарын тоо өссөн байна.
- 8.7 Хүүхдийн хөгжлийг дэмждэг эцэг эх, асран хамгаалагчийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн хүний тоо өсөж, эцэг эхийн эерэг хандлага нэмэгдсэн байна.
- 8.8 Ахмад, залуу багш нарын хамтын ажиллагааг дэмжин, ахмад багш, удирдах ажилтны зөвлөх үйлчилгээнд хамрагдсан багш нарын тоо өссөн байна.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хөтөлбөрийг дараах үр дүнгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

- 9.1 Боловсролын байгууллагын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан багшийн тоо, арга зүй, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлсэн багшийн тоо, кабинетын тоо
- 9.2 ЕБС-ийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний зөрүү багасна, элсэлтийн шалгалтын байр өмнөх оноос ахисан байна.
- 9.3 Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/262 дугаар тушаалын дагуу төрөлжсөн хөтөлбөрөөр хичээллэдэг сургуулийн тоо
- 9.4 Хүүхэд бие даан суралцах, хамтран хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлсэн боловсролын байгууллагын тоо, оролцоо манлайлал, хөгжил хамгааллыг дэмжсэн ажлуудын тоо, оролцогчдын тоо
- 9.5 Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлсэн, туршлага судалсан багшийн тоо
- 9.6 Улсын олимпиад, ур чадвар, эрдэм шинжилгээний хуралд байр эзэлсэн сурагч, багш нарын тоо
- 9.7 Хүүхдийн хөгжлийг дэмждэг эцэг эх, асран хамгаалагчийн түгээн дэлгэрүүлсэн сайн туршлагын тоо, эцэг эхийн эерэг хандлага нэмэгдсэн хувь
- 9.8 Ахмад залуу багш нарын хамтын ажиллагааг дэмжин, ахмад багш, удирдах ажилтны зөвлөх үйлчилгээнд хамрагдсан багшийн тоо.

---oOo---

